

“ХОРГО ХАЙРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр

Улаанбаатар хот

“Хорго Хайрхан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 4 сарын 28-ны өдрийн 11:00 цагт Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, “Монгол даатгал” ХХК байр, 4 давхар, 401 тоот, “Гендекс ҮЦК” ХХК-ийн уулзалтын өрөөнд 10:30 минутаас хувьцаа эзэмшигчдийг бүртгэж эхэлсэн ба хурал 11:00 минутанд эхлэв.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөрийн танилцуулснаар:

“Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй 109,921 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 81.35 хувийг төлөөлсөн 1 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч:

Н.Батбаяр нар хуралд оролцов.

Хурал даргалагч Р.Ариунболд ээлжит хурлыг нээж, ээлжит хурал хуралдуулах тухай “Хорго Хайрхан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн тогтоолыг товч танилцуулав. Улмаар хурлын дэгийг танилцуулав.

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	10:30-10:50
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	5 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах	40 минут
5	Хувьцаа эзэмшигчил үг хэлэх, санал гаргах	20 минут
6	Санал хураалт	20 минут
6	Хурлын завсарлага	5 минут
7	Тооллогын комиссын дарга санал хураалтын дүнг танилцуулах	15 минут
8	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут

Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут
----------------------------	---------

Хурлын дэгийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100%-ийн саналаар батлав.

“Хорго Хайрхан” ХК-ийн ТУЗ-ийн дарга Р.Ариунболд хүрэлцэн ирсэн хүмүүсийг танилцуулав.

Хурлын дарга Р.Ариунболд: Юуны өмнө хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн хүмүүсийг танилцуулья гэж бодож байна. Би өөрөөсөө эхлэн танилцуулья. Намайг Р.Ариунболд гэдэг. Би “Хорго Хайрхан” ХК-ийн ТУЗ-ийн дарга байна. Дараагийн хүн бол

“Монгол даатгал” ХХК-ийн өмнөөс итгэмжлэхээр Н.Батбаяр гэсэн хүмүүс байна.

За ингээд бүгдээрээ танилцсан юм чинь хурлаар хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Бидний хэлэлцэх эхний асуудал бол “Хорго Хайрхан” ХК-ийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт юм.

Энэ хэлэлцэх асуудлын материалыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хурлын дарга Р.Ариунболд: “Хорго Хайрхан” ХК –ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг тарааж танилцуулллаа.

“Хорго Хайрхан” ХК нь сүүлийн жилүүдэд санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас газар тариалангийн чиглэлээр бие даасан үйл ажиллагаа явуулж чадахгүйд хүрсэн ба тус компанийн тариалангийн талбай нь атаршиж, захаасаа элсний нүүдэлд баригдаж цаашид тариа тарих, уринш бэлтгэх боломжгүй болсон.

Цаашид компанийн удирдлагын зүгээс нэгэнт ашиглах боломжгүй болсон хөрөнгийг борлуулан, нэмэлт хөрөнгө оруулалт татаж компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн, одоо байгаа нөөц бололцоо дээрээ тулгуурлан компанийн ашигт ажиллагааг ханган, үйл ажиллагааг хэвийн явуулах тал дээр шат дараалсан ажлуудыг хийхээр ажиллаж байна. Иймд, 2016 оны санхүүгийн болон үйл ажиллагааны зогсонги байдлаас шалтгаалан 2016 онд ногдол ашиг тараах боломжгүй гэж ТУЗ шийдвэрлэсэн байгаа.

2017 оны 3 дугаар сарын 24-ны өдрийн Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны арилжаагаар манай компанийн 81,35%-ийг “Монгол Даатгал” ХХК худалдаж авсан

байгаа. Энэ талаар тус компани Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмуудад заасны дагуу манай компанид албан ёсоор мэдэгдэл хүргүүлж, манай компанийн хувьцааг худалдан авсан болно.

2017 онд компанид менежментийн шинэ багийг оруулж, компанийн үйл ажиллагаа, санхүүгийн ажилагааг сайжруулан, компанийн засаглалыг сайжруулахаар зорилт тавин ажиллаж байна.

Р.Ариунболд үргэлжлүүлэн “Хорго Хайрхан” ХК-ийн ТУЗ-ийн ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцууллаа.

Хурлын дарга Р.Ариунболд: Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул санал хураалтаа явуулах уу.

Хувьцаа эзэмшигч нарт санал өгөх хуудсанд санал өгөх журмыг тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр танилцуулахаар болов.

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр: Хувьцаа эзэмшигчид санал өгөх журмыг тайлбарлав.

Тооллогын комисс саналын хайрцаг хоосон, битүүмжилсэн болохыг хуралд оролцогчдод үзүүлэв. Улмаар хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгцгөөв. Дараа нь тооллогын комисс санал тоолох ажилдаа орж, хуралд тооллогын дүнг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр: Санал хураалтын үр дүнд үндэслэн Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хэлэлцсэн асуудлын дагуу саналын хуудсаар санал авч дараах үр дүнд хүрлээ.

1. 2016 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлахыг зөвшөөрсөн саналын эрхтэй хувьцааны тоо 109,921 ширхэг буюу нийт саналын эрхтэй хувьцааны 81,35%, хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцааны 0% татгалзсан санал байхгүй, түдгэлзсэн санал байхгүй тул баталсанд тооцов.

Хурлын дарга Р.Ариунболд: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэн хурлаас гарах шийдвэрүүдийг танилцуулав.

1. Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Хорго Хайрхан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж тооцсугай.
2. Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Хорго Хайрхан” ХК-ийн 2016 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хурлын дарга Р.Ариунболд: Хурал хаасныг мэдэгдэв.

Хурал 2017 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн 12 цаг 05 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д.САЙНБАЯР

ХУРЛЫН ДАРГА:

Р.АРИУНБОЛД

